



ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мейл: jargalsaihan_tuv@yahoo.com
Факс: 01-272-22582

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465
И-мейл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: Ц.Саранчимэг
Утас: 70273204
И-мейл: tsaranchimeg@yahoo.com

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:
Төв аймаг Зуунмод сум 6-р баг
Төрийн байгууллагуудын 2-р ордон
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2017 оны 03 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2017/60/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 13-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн ахлах аудитор Ц.Саранчимэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дүгээр сарын 14-нд Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль, Боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Төв аймгийн Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хөгжсөн багшаас, чадварлаг сурагч” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн ИТХурал баталж Төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Төв аймгийн Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль–ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 66 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 0 асуудал эрсдэл өндөр, 7 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 21 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 0 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу эрсдэлгүй, мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах 2 буюу шаардлагагүй гэж үзлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Acoullus” програм хангамж ашиглажээ.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1174317.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 0 төгрөгийн төсөв баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл 2016 онд 1210499.6 мянган төгрөгөөр батлагдсанаас аймгийн Засаг даргын 2016 оны 12-р сарын 23-ны өдрийн А/719 тоот захирамжаар 34926.0 мянган төгрөгийн хэмнэлтийг зарим төсөвт байгууллагын өрийг шийдэхэд зохицуулах талаар гарсан захирамжийн дагуу төсөв буурч батлагдсан байна. Тодотгосон төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад 701.2 мянган төгрөгийн хэмнэлтийг гарсныг татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт нь 295.2 мянган төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөөтэй ба тайлант онд 296.5 мянган төгрөгийн орлого оруулж батлагдсан төлөвлөгөөг 1.3 мянган төгрөг буюу 100.4 хувиар биелүүлсэн байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 4672.0 мянган төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 4672.0 мянган төгрөг нь хичээл үйлдвэрлэлийн зардалд зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

Шилэн дансны мэдээлэл:

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тайлант онд мэдээлбэл зохих 95 мэдээлэлээс 88 мэдээлэлийн хугацаанд, 14 мэдээллийг хугацаа хоцроож 7 мэдээлэлийг мэдээллээгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 60 эрсдэлтэй асуудалд 60 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 55 хувь буюу 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

Аудитын явцад материаллаг хэмжээний 13172.3 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд томилолтын зардалд 46.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 366.1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 654.2 мянган төгрөг, 1067.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг шууд зардалд хаасан нь Төсвийн тухай хуулийн 8.2-д Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: НБББаримт бичигийг үндэслэн шууд зардал хаасан бичилт хийхгүйгээр, тооцооны дансаар заавал дамжуулан бүртгэж тайлагнаж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Төсөвт тайлан бүлэгтэйгээс өр авлагын мэдээг санхүүгийн тайлантай тулгахад түлш халаалтын зардал 11540.5 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардал 547.9 мянган төгрөг байгаа бөгөөд санхүүгийн тайланд ХАОАТ 16.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өр авлагын мэдээг үнэн зөв мэдээлж байгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-д санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн яаманд мэдээлэгдэж байгаа ө тайлангийн өр авлагыг төсвийн тайлан бүлэгтэй д шивэхдээ үнэн зөв мэдээлж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд цалин, нэмэгдэл, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зарцуулалтыг тайлагнахдаа тодотгосон дүнгээр тайлагнаагүй 3643.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг зөрчсөн байна гэснийг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн гүйцэтгэлийн тайланд ө тайлангийн төсвийн тайлан бүлэгтэйгийн хуулгатай тохируулан залруулсан.

2. Барилга байгууламжийн элэгдэл 46943.7 мянган төгрөг, машин тоног төхөөрөмжийн элэгдэл 95.6 мянган төгрөг, тавилга эд хогшилийн элэгдэл 1965.5 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 435.3 мянган төгрөг нийт 49440.1 мянган төгрөгийн элэгдэлийн зардал дутуу байгуулагдсан, актлагдсан үндсэн хөрөнгө хасахдаа элэгдэлийн зардалд 9415.5 мянган төгрөгийн бичилт хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл

ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна гэсэн заалтыг зөрчсөн байна .

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1-д аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна гэсний дагуу үндсэн хөрөнгийн элэгдэлийн зардлыг санхүүгийн програмаас дутуу татсан, актлагдсан үндсэн хөрөнгийг элэгдэлийн зардал бичсэн зэргийг залруулга хийхээр шийдвэрлэв.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БСШУЯмнаас ирсэн судалгаатай тулган баталгаажуулахад 13448.3 мянган төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4-д Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Боловсролын газраас ирүүлсэн хөрөнгө оруулалтын судалгаатай тулган баталгаажуулж зөрүүтэй орлого аваагүй байсан хөрөнгийн талаар ярилцаж орлого авахаар болж залруулга хийхээр шийдвэрлэв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 125387.1 мянган төгрөгийн алдаа залруулагдсан болно. Материаллаг бус залруулагдаагүй алдаагүй болно.

Анхаарал татахуйц асуудлууд:

Батсүмбэрийн сумын сургуульд 1116 сурагчид суралцаж, дотуур байранд 240 хүүхэд хамрагддаг, тойрогын 2 бага сургуультай, 5 тойрогын цэцэрлэгтэй, цэцэрлэгт 275 хүүхэд хүмүүждэг байна. Сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөв 1.7 тэрбум, үндсэн болон эргэлтийн хөрөнгө 5.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэж, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг 1 нягтлан бодогч дангаараа хийж гүйцэтгэж байгаа нь ажлын ачаалал их байгаа нь анхаарал татаж байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 138559.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс материаллаг 125387.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 13172.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 он оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Батсүмбэр сумын Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2016.06.20-ны өдрийн № 84 дугаар албан

бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ц.САРАНЧИМЭГ

Огноо: 2017.03.13